



リビングガイド(モンゴル語)

ОРШИН СУУХ ХӨТӨЧ

ЖАЙКА-гийн сургалтанд оролцогчдод зориулав

Кансай



Кансай Төв
Японы Олон улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
(ЖАЙКА Кансай)

(2019 оны 5 дүгээр сарын байдлаар)

Гарчиг

I.	ЖАЙКА Кансай	1
II.	Ойр орчмын газрууд руу явах	
	Нада, Иваяагийн ойр орчим	2
	Галт тэрэг таныг хаана ч хүргэж өгнө	5
III.	Банк	7
IV.	Спортын байгууламж	11
V.	Моск (Лалын сүм), Христийн сүм	12
VI.	Гадуур явах	13
VII.	Чухал мэдээлэл ба Дүрэм	
	1. Японд таатай оршин суухад	23
	2. Эрүүл мэндийн координатораас мэдээлэл хүргэж байна	25
	Хавсралт 1 Зохиогчийн эрхийн тухай баримтлах бодлого	26
	Хавсралт 2 ЖАЙКА-гийн байгаль орчны бодлого	27
	Хавсралт 3 Ач тустай зарим цахим хуудас, аппликейшн	28


I. ЖАЙКА Кансай




Кансай Төв
Японы Олон улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
(ЖАЙКА Кансай)

Кобэ, Чю-о кү, Вакино-хама кайган доори 1-5-2
Хиого 651-0073, ЯПОН
Утас: (078)261-0341
Улс хоорондын дуудлага: +81-78-261-0341
Факс: (078)261-0465

II. Ойр орчмын газрууд руу явах Нада, Иваягийн ойр орчим






Санномия - ЖАЙКА Кансай
 2.7 км

Блюмер ХАТ КОБЭ (Худалдааны төв)


(Ажиллах цаг 10:00-21:00)

(Супермаркет 10:00-22:00, Ресторан 11:00-22:00, Театр 10:00-24:00)

1-р давхар




- (1) Нярайн хэрэгсэл & Тоглоом
- (2) Зургийн студи
- (3) Супермаркет
- (4) Гуанзны заал (Хөнгөн зууш)
- (5) Мак Дональдс
- (6) Эм, өдөр тутмын хэрэглээ
- (7) Дэлгүүр
- (8) Хувцас (Эмэгтэй, хүүхдийн)
- (9) Шүдний клиник
- (10) Хувцас (Эмэгтэй, хүүхдийн)
- (11) Хими цэвэрлэгээний газар
- (12) Гар утасны дэлгүүр
- (13) Гэр ахуй, гал тогооны хэрэгсэл, бусад
- (14) Хувцас



ЖАЙКА
Кансай

2-р давхар



- (15) Синема комплекс (Кино театр)
- (16) Гэйм төв
- (17) Ресторан (Кофены газар, рамений газар, бусад)
- (18) Номын дэлгүүр
- (19) Дэлгүүр (UNIQLO/ЮНИКЛО, ABC гутлын дэлгүүр, 100 иений дэлгүүр, үсчин, бусад)

Галт тэрэг таныг хаана ч х үргэж өгн ө.....! (JR / Ханкю / Ханшин т өм өр зам)



JR-ын төмөр замын сүлжээний зураг

Галт тэрэгний билет хэрхэн худалдаж авах (JR-ын тохиолдолд)

- ☆ Төмөр замын сүлжээний зурагнаас зорьсон газар хүртэлх тээврийн зардлыг хайж олно.
- ☆ Билетний автомат машинд мөнгө хийнэ.
- ☆ Дэлгэцэн дээр / товчлуураар билетний үнийг сонгоно. Машинаас билет (мөнгөний хариултын хамт) гарч ирнэ.



Дуудлагын товчлуур
(Асуудал гарсан тохиолдолд)



Цуцлах товчлуур
Зоосон мөнгө

Дэвсгэрт мөнгө

Билет, мөнгөний хариулт

Зорчих мэдээлэл

JR, Нада	--	JR, Санномияа	¥120
JR, Нада	--	JR, Осака	¥410
JR, Нада	--	JR, Киото	¥1,080

* Кансай бүсийн гол газруудын аяллын мэдээллийн талаар Хуудас 12-оос хойшхыг харна уу.



Галт тэргэнд суухдаа

- ☆ Билетээ зориулалтын нүх рүү нь хийнэ.
Билет уншигчийн хаалга нь онгойно.
Билет уншигчийн хаалганы төгсгөлд хийсэн билет гарч ирэх ба билетээ аван, зорьсон буудал дээр буух хүртлээ биедээ авч явна.
- ☆ IC картын зориулалтын:
Зөвхөн IC карт (Нэгдсэн схемт карт) уншдаг.
- ☆ Суух платформ руугаа явна.



Зорьсон газартаа х үрсний дараа

- ☆ Буухдаа билетээ зориулалтын нүх рүү нь хийнэ.
Билет уншигчийн хаалга нь онгойно.
Билет уншигч таны билетийг авч үлдэнэ.



JR, Нада буудалд зөвхөн "Энгийн" галт тэрэг зогсдог.

Та Санномия болон Кобэ гэсэн том буудлууд дээр "Экспресс" эсвэл "Супер экспресс" галт тэрэгнүүдтэй таарах байх. Гэхдээ эдгээр нь Нада буудал дээр зогсдоггүй. Нада буудал руу харихдаа эдгээр галт тэрэгнүүдэд суухгүй байхыг анхаараарай.

Галт тэрэгний ТӨРЛҮҮД



Нада буудалд ЗОГСОНО.



Нада буудалд ЗОГСОХГҮЙ.



Нада буудалд ЗОГСОХГҮЙ.

III. Банк

Японд байх хугацаанд тань ЖАЙКА-гаас олгогдох амьжиргааны зардлыг гаргаж авахдаа, ЖАЙКА-гийн банкны данснуудын нэгийг нь хэрэглэнэ.

ЖАЙКА-гийн банкны данс нь, зөвхөн бэлэн мөнгө гаргаж авах болон дансны үлдэгдлийг шалгах л үйлдэлтэй.

ЖАЙКА-гийн банкны дансанд мөнгө хадгалуулах болон данснаас мөнгө шилжүүлэх гэх мэт санхүүгийн гүйлгээ хийх боломжгүй.

ЖАЙКА-гаас танд олгогдсон мөнгийг ЖАЙКА төв доторх "Бэлэн мөнгөний автомат машин", эсвэл Сүмитомо Мицүи Корпораци Банк (SMBC,三井住友銀行)-ны Бэлэн мөнгөний автомат машин (АТМ)-аас гаргаж авах боломжтой.

Данснаас мөнгө гаргаж авахдаа, гүйлгээний баримтыг марталгүй аваарай. Уг баримтыг зориулалтын хуудсанд нааж, дараа нь ЖАЙКА-д хураалгах шаардлагатай.

- ★ Мөнгө гаргаж авахад, PIN (Personal Identification Number (Хувийн Таних Дугаар)) код хийх шаардлагатай; Хэрвээ та 3 удаа дараалан PIN кодоо буруу хийвэл, таны банкны карт хүчингүй болно. Та өөрөө төлбөрийг нь (1,080 иен) төлөн, картыг дахин гаргуулах шаардлага гарна.

1. ЖАЙКА Кансай төвийн доторх "Бэлэн мөнгөний автомат машин"

Үйлчилгээний цаг:	08:45 - 19:00	Даваа - Баасан
	09:00 - 17:00	Бямба
	Хаалттай	Ням, Баярын өдрүүд болон
		Банкны амралтын өдрүүд

Тэмдэглэл:

1) Тус Бэлэн мөнгөний автомат машин нь зөвхөн дэвсгэрт мөнгөөр үйлчилнэ. --1,000/5,000/ болон 10,000 иен.

2) Бэлэн мөнгөний автомат машиныг ажиллуулснаас хойш 1 минутын дотор мөнгө, банкны карт, гүйлгээний баримтаа авна уу; аваагүй тохиолдолд машин руугаа буцаж орно.


3) Машины заавар зөвхөн Япон хэл дээр гарна; Англи хэл дээрх зааврыг Ресепшнээс авч харна уу.



2. Бэлэн мөнгөний автомат машин (АТМ)

☆ Үйлчилгээний цаг болон үйлчилгээний шимтгэл (SMBC):

	0:00	8:45	18:00	24:00
Даваа - Баасан				
Бямба, Ням болон Үндэсний баярын өдрүүд				



мөнгө гаргаж авахад шимтгэлгүй.



мөнгө гаргаж авах бүрт 108 иений шимтгэлтэй.

☆ **Зоосон мөнгө гаргаж авах боломжтой:**

SMBC-гийн зарим салбар банкнаас--зөвхөн ажлын өдрүүд (Даваагаас Баасан хүртэл)-ийн 8:45 - 18:00 цагийн хооронд

※ Дараах 24 цагийн дэлгүүрүүд доторх АТМ-ээс гаргаж авах боломжтой. Гагцхүү, гүйлгээ тус бүрээс үйлчилгээний шимтгэл суутгагдана.

(Е-нет  , LAWSON ATM  , 7 БАНК АТМ )

Үйлчилгээний шимтгэл:

Ажлын өдрүүд			Бямба / Ням / Баярын өдрүүд
0:00-08:45	08:45-18:00	18:00-24:00	0:00-24:00 өдрийн 24 цагийн турш
¥216	¥108	¥216	¥216

3. Валют солих цэг

Гадаад валютыг, SMBC-гийн Санномияа салбарын 1-р давхрын "Валют солих цэг" дээр солиулах боломжтой. (10-р хуудасны газрын зургийг харна уу.)

☆ Үйлчилгээний цаг: **11:00 - 19:00** **Даваа - Баасан**
10:00 - 18:00 **Бямба, Ням, Баярын өдрүүд**

Дээр дурьдсан цэгт Япон иенийг гадаад валютаар солиулж болох ба мөн жуулчны чек худалдаж авах боломжтой.

※ Валют солиулахад, оршин суугаа хаяг болон утасны дугаар шаардагдаж магадгүй. Эдгээр мэдээллийг 1-р хуудаснаас харах боломжтой.


Сүмитомо Мицүй Корпорацн Банк



ATM: Бэлэн мөнгөний автомат машин

Процедур

①



"English (Англи хэл)" дээрх зааврыг сонгоно.

②




"Withdrawal (Мөнгө гаргаж авах)"-ыг дарна.

③



Банкны картаа оруулна.


④



PIN кодоо хийнэ.

* 3 удаа PIN кодоо буруу хийсэн тохиолдолд, таны банкны карт хүчингүй болно.

⑤




Гаргаж авах мөнгөн дүнгээ хийнэ.

"Confirm (Бататгах)"-ыг дарна.

Гүйлгээнийхээ баримтыг марталгүй аваарай.



JR, Санномия буудал



Санномия центр худалдааны гудам




Кобэ хотын захиргаа (төв) ба түүний эргэн тойрон

IV. Спортын байгууламж

Оожи спортын төв

- 1) Байгууламж ашиглалтын хураамж ¥ 350/ нэг удаагийн ашиглалтанд
(Дасгал сургуулилалтын өрөө)
- 2) Ажиллах цаг 09:00 - 21:00 (хүлээн авах цаг 20:30 хүртэл)
- 3) Тэмдэглэл: Өрөөн дотор өмсөх, цэвэрхэн ултай гутал авч очно уу. (Сандаль өмсөх юм уу хөл нүцгэн байж болно.) Биеийн тамирын хувцас өмсөнө үү. (Жийнс болохгүй.)



ЖАЙКА Кансай-аас явганаар 30 минут



ХАТ Нагиса но юу (Байгалийн халуун рашаан, спа)

- 1) Хэрэглээний хураамж (ажлын өдөр) ¥ 820 / нэг удаагийн хэрэглээнд
(Бямба, Ням, Баярын өдөр) ¥ 900 / нэг удаагийн хэрэглээнд
Та алчуураа өөрөө авч очно уу. Эсвэл тэндээс нь худалдаж авна уу.
- 2) Ажиллах цаг 10:00 - 25:00 (хүлээн авах цаг 24:00 хүртэл)

3) Нийтийн халуун усанд орох арга

1. Юуны өмнө, гутлаа гуталны шүүгээнд хийж, цоожилно.
100 иен шаардлагатай ба хэрэглэсний дараа буцаж ирдэг.
Гутлын шүүгээний түлхүүрийг Ресепшн дээр авч очно.
2. Хэрэглээний хураамжаа төлсний дараа, IC бугуйны зүүлт хүлээн авна.

ONSEN (халуун рашаан)-д орох дадал заншилтай танилцаж, сайн үйлчлүүлэгч болцгооё.

<https://nagisa-u.com/en/>

http://www.japan-guide.com/e/e2292_how.html



ХАТ Нагиса но юу

ЖАЙКА Кансай-аас явганаар 8 минут (650 метр)

V. Моск (Лалын сүм), Христийн сүм

Кобэ Ислам Моск (Исламын соёлын төв)

Мөргөлийн цагийн хуваарийн талаар Ресепшнээс лавлана уу.

УТАС: (078) 231-6060

Кобэ, Чю-о кү, Накаяматэ доори 2-25-14

<http://kobe-muslim-mosque.com/>

И-мэйл: kobemasjid@gmail.com



Накаяматэ Католик сүм


Ням гаригийн мөргөл 09:00-17:00

Ням гаригийн үйлчилгээ: (Англи хэл дээр) 11:15-12:15

УТАС: (078) 221-4682

Кобэ, Чю-о кү, Накаяматэ доори 1-28-7

Цахим хуудас байхгүй.



Кобэ нэгдмэл сүм (Шашны урсгал үл харгалзана.)

Ням гаригийн хуваарь үдээс өмнө 09:30-10:45 (Ням гаригийн үйлчилгээ)

үдээс өмнө 10:40-11:10 (Нөхөрлөлийн цаг)

үдээс өмнө 11:10-12:00 (Ням гаригийн сургууль)

УТАС: (078) 871-6844

Кобэ, Нада кү, Нагаминэдай 2-4-4


<http://kobeunionchurch.org/>

* Цахим хуудаснаас нь сүм хүртэлх тээврийн хэрэгслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.



VI. Гадуур явах

Кансай бүсийн орон нутгуудын газарзүйн байршил



Японоор тавтай аялахын тулд хамгийн тохиромжтой галт тэрэг / нислэг / автобусны маршрутыг олоход тань дараах цахим хуудаснууд таны аяллыг замчлах навигаци болно.

<http://www.hyperdia.com/en/>

<https://roote.ekispert.net/en>

<https://world.jorudan.co.jp/mln/en/>

КОБЭ

Гадуур явах нь, Кобэд байх хугацаандаа өөрийгөө хөгжөөж, сэргээх аргуудын нэг юм. Кобэ хот дотор болон хотын гадуур сонирхол татах зүйл маш их байдаг. Кобэ хот дотор болон хотын ойрхон газруудаар "Өдрийн аялал" хийх боломжуудыг доор товчхон танилцууллаа. Кобэ дэх аялал, тээвэр, Кобэгийн амьдралын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, хөтөч номнуудаас харах юм уу, эсвэл дараах "Мэдээллийн төвүүд"-ээс лавлана уу.

(1) Аялал жуулчлалын албан ёсны цахим хуудас:

<Кобэ> <http://plus.feel-kobe.jp/>

<Хиого> <http://www.hyogo-tourism.jp/english>

(2) Кобэ хотын мэдээллийн төв (Кобэгийн мэдээлэл)

Өдөр бүр ажиллана: 09:00-19:00

09:00-15:00 (12/31-1/2)

Утас: (078)322-0220

Байршил: JR, Санномия буудлын өмнөд талд,
Зүүн гарц

Ц. Х.: <http://hello-kobe.com/hello-stmap.html>

(3) Кобэ олон улсын комьюнити төв (KICC)

Ажиллана: 10:00-20:00 (Даваа - Баасан)


10:00-17:00 (Бямба)

Амарна: Ням болон Баярын өдрүүд

Утас: (078)291-8441

Байршил: Кобэгийн арилжаа, худалдаа, аж үйлдвэрийн төв байр,
2-р давхар

Ц. Х.: http://www.kicc.jp/index_en.html




КОБЭ

☆ Рокко уул

Рокко уул нь 931 метр өндөр. Хотын автобус, кабел машин таныг уулын оройд хүргэж өгдөг хэдий ч, та өөрөө авирах боломжтой бөгөөд өөрөө авирах нь илүү зугаатай. Ууланд байрласан Альпын ботаникийн цэцэрлэг, Атлетикийн талбай гэх мэт жуулчдад зориулсан байгууламжуудтай танилцах боломжтой.
Кобэ, Осакагийн гайхамшигтай үзэсгэлэнт далайн эргийг мөн марталгүй хараарай.

Англи хэл дээрх дэлгэрэнгүй мэдээллийг "ROKKOSAN.Com English"-ээс харна уу.

<https://www.rokkosan.com/en/access/>



☆ Гүүрний үзүүлэнгийн төв (Акаши Кайкё гүүр)

Гүүрний үзүүлэнгийн төв нь Акаши Кайкё гүүр (3,911 метр ᠔ үүжин гүүр)-ний ойролцоо байршилтай.

Үзүүлэн нь дэлхийн алдартай гүүрнүүд болон тэдгээрийн архитекторын өндөр технологийг харуулсан зургаар дүүрэн.

Хураамж: ¥310 (насанд хүрэгчид)
<http://www.hashinokagakukan.jp/index.php>

Ажиллах цаг:

09:15 - 17:00 (16:30-аас өмнө орно.) (5-р сараас 7/19, 9-р сараас 11-р сар)

09:15 - 18:00 (17:30-аас өмнө орно.) (7/20 - 8-р сар)



09:15 - 16:30 (16:00-аас өмнө орно.) (12-р сараас 2-р сар)

Хөтөчтэй аяллын хураамж: ¥3,000 (насанд хүрэгчид)

Хөтөчтэй аяллын цагийн хуваарь: 9:30-12:10, 13:30-16:10

Урьдчилан захиалах шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах "Дэлхийн гүүр" цахим хуудаснаас харна уу.

<http://www.jb-honshi.co.jp/english/bridgeworld/index.html>



★ Кобэ Оожи амьтны х үрээлэн

150 орчим төрөл зүйлийн 800 амьтан тэжээдэг, ногоон орчноор хүрээлэгдсэн, хотын төв дунд байршилтай Кобэ Оожи амьтны хүрээлэн нь чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх газруудын нэг юм. Халуун орны, шөнийн амьтад торонд байдаг ба зугаалгын парк, амьтан судлалын мэдээллийн музей гэх мэт янз бүрийн байгууламжуудтай. Кобэ Оожи амьтны хүрээлэн нь, коала баавгай, аварга том пандагийн аль алиныг нь ажиглах боломжтойгоороо их онцлог юм.




Ажиллах цаг 09:00 - 17:00 (16:30-аас өмнө орно.)
(3-р сараас 10-р сар)
09:00 - 16:30 (16:00-аас өмнө орно.)
(11-р сараас 2-р сар)
Амарна Лхагва, 12/29 - 1/1
Хураамж ¥600
Цахим хуудас <http://www.kobe-ojizoo.jp/sp/guide/fl/>



Байршлыг газрын зурагнаас харна уу. (2-р хуудас)
ЖАЙКА Кансай-аас явганаар 30 орчим минут.

★ Кобэ Сума далайн ерт өнцийн парк

Тус парк нь, 600 орчим төрөл зүйлийн 13,000 далайн амьд организмын цуглуулгатайгаараа онцлог юм. Аварга махчин загаснууд, ангиан загаснууд нь 1,200 тонны багтаамж бүхий хиймэл давалгаатай усан танканд сэлдэг. Дельфины гайхамшигтай тоглолт, хүүхдүүд наадан зугаацах хэсэг болон тэнгисийн халиуны байр зэрэг нь хүмүүсийг зугаацуулах олон үзүүлбэрүүдийн ердөө нэгээхэн хэсэг нь л юм.



Ажиллах цаг 09:00 - 17:00 (16:00-аас өмнө орно.)
Амарна Лхагва (12-р сараас 2-р сар)
Хураамж ¥1,300
Цахим хуудас <http://sumasui.jp/abroad/english.html>



Явганаар 5 минут

Сума далайн ертөнцийн парк
(Сума Кайхин Сүйзोकү-эн)



Нийт тээврийн зардал (Нэг талдаа)

JR	Нада	→	Сума-Кайхин ко-эн	¥220
			16 минут	

ХИМЭЖИ

☆ Химэжи цайз

Химэжи цайз нь 1601 онд баригдсан ба үндэсний баялаг, Дэлхийн өвд бүртгэгдсэн. Тус цамхагийн загвар хийц нь, цамхагийг гадны халдагаас хамгаалах тактикийгаар зохион бүтээгдсэн.

Хамгийн том бөгөөд жинхэнэ Япон цайз юм. Цайзны гол цамхагийн оройгоос Химэж и

орчмын хотыг бүхэлд нь харах боломжтой.

Ажиллах цаг өдөр бүр	09:00 - 17:00 (4/27 - 8/31) 09:00 - 16:00 (9/1 - 4/26)
Хураамж	¥1,000



Зохиогчийн эрхээр хамгаалагдсан ©:



JR, Химэжи буудал

Химэжи цайз (JR, Химэжи буудлаас явганаар 20 минут.)



* Санномия буудлаас **Шин-кайсоку** (Супер экспресс)-д дамжиж сууна.

Нийт тээврийн зардал (Нэг талдаа)			
JR	Нада	→ 55 минут	Химэжи
			¥970

Химэжи цайзны албан ёсны цахим хуудас:

<http://www.himejicastle.jp/en/index.php>

<http://www.himeji-kanko.jp/en/>

ОСАКА


Осака нь баруун Японы худалдаа, аж үйлдвэр, санхүүгийн төв хот юм. Маш олон бизнес үйл ажиллагаа болон бизнесийн газрууд байхаас гадна, Осака нь түүхэн газрууд болон сонирхол татахуйц төрөл бүрийн соёлын газруудтай. Осакагийн төв хэсэг руу явахад, JR-ын Канжо-сэн (Loop Line, тойрог хэлбэрийн шугам) болон метроны шугамнуудын аль нэгэнд нь сууж, хялбархан хүрэх боломжтой. Тээврийн сүлжээний зургийг харна уу.

Осака жуулчдын хөтөч, цахим хуудас:

<http://www.osaka-info.jp/en/>

Осака руу явах

• <Ханшин төмөр зам>



Нийт тээврийн зардал (Нэг талдаа)			
Ханшин	Иваяя	→ 35 минут	Үмэда ¥300

• <JR төмөр зам>



Нийт тээврийн зардал (Нэг талдаа)			
JR	Нада	→ 30 минут	Осака ¥410

Санал болгож буй газрууд


Осака цайз → 19-р хуудаснаас харна уу.
Юниверсал Студио Япон (USJ) → 20-р хуудаснаас харна уу.
Осака аквариум КАЙ-ЮУКАН → 20-р хуудаснаас харна уу.

Осака жуулчдын мэдээллийн төв, Үмэда

Ажиллах цаг өдөр бүр 08:00 - 20:00

УТАС : (06) 6345-2189



* "МЭДЭЭЛЭЛ (INFORMATION)" гэсэн хаягтай,
JR, Осака буудлын хойд төв гарц (North Central Gate), 1-р давхар



Осака цайз

★ **Осака цайз**

Осака цайзыг, удаа дараалсан иргэний дайны улмаас хуваагдсан байсан улсаа нэгтгэсэн, Японы хамгийн нэртэй жангнуудын нэг *Тоёотоми Хидэ-ёши* бариулсан. Тус сүрлэг цайз нь 1586 онд баригдаж дууссан боловч, 2 удаа гал түймэрт өртөж байсан түүхтэй. 1931 онд Осакагийн иргэд *Хидэ-ёши* жанжны хүндэтгэлд зориулан, цайзны гол цамхагийг дахин бариулахаар сан байгуулсан. Гол цамхаг (*Тэншю-каку*)-т нь сонирхол татах төрөл бүрийн түүхийн үзүүлэнгүүд байдаг.



Нийт тээврийн зардал (Нэг талдаа)				
JR	Нада---	Осака	→	Осака-жо коо-эн
		44 минут		(JR, Осака цайз парк)
				¥550

Осака цайзын цахим хуудас:

<http://www.osakacastle.net/english/>

★Юниверсал Студио Япон (USJ)

Цэнгэлдэх хүрээлэн

Аж. цаг: <http://www.usj.co.jp/e/parkguide/calendar.html>


Хураамж: ¥7,900 (Нэг өдрийн билет)

Цахим хуудас: <http://www.usj.co.jp/e/>

* Роккомичи буудлаас Кайсоку (Экспресс)-д дамжиж сууна. Осака буудал хүртэл 30 орчим минут орох ба Осака буудал дээр Канжо-сэн (Loop Line, тойрог хэлбэрийн шугам)-д дамжиж сууна.



Тээврийн зардал
JR, Нада → JR, Юниверсал сити
¥550/ нэг талдаа (47 минут)



★Осака аквариум КАЙ-ЮУКАН

Тэмпо-зан Харвор тосгонд байрлах, дэлхийн хамгийн том аквариумуудын нэг.

Өдөр бүр ажиллана 10:00-20:00 (19:00 цагаас өмнө орно.)※

Хураамж: ¥2,300 (насанд хүрэгчид)

※ Ажиллах цаг нь улирлаар өөрчлөгддөг. Дэлгэрэнгүй мэдээллийг "Осака аквариум КАЙ-ЮУКАН"-ы дараах цахим хуудаснаас харна уу.

Цахим хуудас: <http://www.kaiyukan.com/language/eng/index.htm>

*Роккомичи буудлаас Кайсоку (Экспресс)-д дамжиж сууна. Осака буудал хүртэл 30 орчим минут орох ба Осака буудал дээр метроны Мидоо-сүжи шугамд дамжин, Хонмачи буудал дээр Чю-о шугамд дамжиж сууна.



Тээврийн зардал
JR, Нада → Осака / Үмэда (M16) → Осака-ко (C11)
¥410 ¥280
¥690/ нэг талдаа (57 минут)


KYOTO

Киото нь, 794 оноос 1868 он хүртэл Японы нийслэл байсан ба 1,600 буддын сүм хийд болон 850 Шинто шашны сүмтэй. Японы хамгийн үзэсгэлэнтэй цэцэрлэгүүд, ордонгуудтай. Одоо 1.5 сая оршин суугчтай, орчин үеийн хот болсон хэдий ч, Киото нь Японы уламжлалт соёл, урлаг, гар урлал болон уламжлалт зоогийн төв нь байсаар байна. Киотогоор явган аялах нь, хамгийн таатай дурсамжуудын нэг нь болдог. Эсвэл, төмөр замын Киото буудалд байрлах "Киото сити" автобусны терминалаас автобусны нэг өдрийн билет (¥500) авбал, жуулчдын сонирхлыг татдаг гол газруудаар явахад хялбар байж болох юм. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, "Киото аяллын хөтөч"-ийг харна уу. Цахим хуудас: <http://www.Kyoto.travel/>

Тээврийн зардал

Нада → Киото


¥1,080/ нэг талдаа
(1 цаг орчим)



Киото жуулчдын мэдээллийн төв

Киото буудлын байр, 2-р давхар
Англи хэлний хөтөч байдаг.

Өдөр бүр 8:30-19:00
Утас: 075-343-0548
<http://www.kyototourism.org/en/travel-info/tourist-info-centers/index.html>



НАРА

Нара нь Японы алдартай нийслэл байсан ба эртний шүлэгч Нараг нэгэнтээ "Гүйцэд дэлбээлсэн анхилуун үнэрт цэцэг" хэмээн тодорхойлж байжээ. Нара нь, эртний Тэнпио үеэс л Японы агуу их урлагийн өлгий нутаг нь байсан ба соёлын гол сүнс нь байсан юм. Ямато муж (өнөөгийн Нара муж)-ийн эртний, дэлхийд алдартай буддын хийдүүд, Шинто шашны сүмүүд нь тэдний нандин түүхийг бидэнд өвлүүлж өгсөн билээ.

Өхөөрдөм хөөрхөн буганууд (Шинто шашинд бугыг бурхны элч гэж үздэг.) гүйлдэх Нара цэцэрлэгт хүрээлэн танд таалагдах болно. Уг цэцэрлэгт хүрээлэнгийн өргөн уудам, нээлттэй ногоон талбай нь Японы балар эртний түүхийг өөртөө агуулсан байдаг. Нарагаар явган алхахад тайван уур амьсгалтай, таатай байдаг. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, дараах цахим хуудсуудыг харна уу.

Нара мужийн захиргааны Аялал жуулчлалын агентлаг
<https://www.visitnara.jp/>

Нара хотын жуулчдын нийгэмлэг
<https://narashikanko.or.jp/en/info/>

Тээврийн зардал
Нада → Нара
¥1,240/ нэг талдаа
(90 минут)



VII. Чухал мэдээлэл ба Дүрэм

1. Японд таатай оршин суухад

(1) "Гадуур хонох тухай мэдэгдэл хуудас"-ыг хураалгах

Хэрвээ та ЖАЙКА-гаас заагдсан байрнаас гадуур хонохыг хүсвэл, зөвхөн Баасан, Бямба гариг болон баярын өдрийн өмнөх өдрүүдэд боломжтой. (Заагдсан байранд хоноогүй өдрийн өрөөний төлбөрийг буцааж олгохгүй.)

"Гадуур хонох тухай мэдэгдэл хуудас" (ЖАЙКА Кансай-ын Ресепшн дээрээс авах боломжтой.)-ыг урьдчилан хураалгаж, таныг эзгүй байх хугацаанд яаралтай үед холбоо барих хүний талаарх мэдээллийг ЖАЙКА-д мэдээлнэ үү. ЖАЙКА Кансай-д байрлаж буй сургалтанд оролцогчид: Тус мэдэгдэл хуудсыг Ресепшнд хураалгана уу. Зочид буудалд байрлаж байгаа тохиолдолд: Сургалт хариуцсан ажилтнаас и-мэйлээр лавлаж, зааврыг нь дагана уу.

Гадуур хонох тухай мэдэгдэл хуудас	
Зөвхөн Баасан, Бямба гариг болон баярын өдрүүдийн өмнөх өдрүүдэд	
Миний бие, энэхүү мэдэгдэл хуудсаар гадуур хонох тухайгаа мэдэгдэж, гарын үсгээ зурсан болно. Гадуур хонохтой холбоотойгоор үүсэх ямар	
Овог нэр	
Сургалтын нэр	
ЖАЙКА Кансай-д байрлаж буй өрөөний дугаар эсвэл Буудалгаж буй газар (зочид)	
Гадуур хонохоор явах	<input type="checkbox"/> Өдөр <input type="checkbox"/> Сар <input type="checkbox"/> Цаг <input type="checkbox"/> / <input type="checkbox"/> хоног <input type="checkbox"/> Баасан <input type="checkbox"/> Бямба <input type="checkbox"/> Баярын өдрийн өмнөх
Буцаж ирэх өдөр	<input type="checkbox"/> Өдөр <input type="checkbox"/> Сар <input type="checkbox"/> Цаг <input type="checkbox"/> / <input type="checkbox"/>
Гадуур хонох хугацаанд яаралтай үед холбоо барих мэдээлэл	
Холбоо барих хүний овог нэр эсвэл Буудаллах	
Утасны дугаар	
Оршин суугаа хаяг	
	Он сар өдөр
	Гарын үсэг

(2) Замын хөдөлгөөний дүрэм

Өөрийнхөө аюулгүй байдлыг хангахад, замын хөдөлгөөний дүрмийг ажиглана уу. "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдамж"-ийг уншиж танилцана уу.

http://www.npa.go.jp/koutsuu/kikaku/trafficsafety/traffic_safety_english.pdf



(3) Таны хувийн дүрс

Таны оролцож буй "Мэдлэг Хамтын Бүтээн байгуулалт Хөтөлбөр"-ийн турш авсан таны хувийн дүрсийг буулгасан гэрэл зураг, бичлэгийг ЖАЙКА албан ёсны зорилгоор ашиглах магадлалтай.



(4) Гудамжинд хүний зураг дарахдаа - Урьдчилан зөвшөөрөл аваарай.

Гадуур явж байхдаа, Японы хөөрхөн хүүхдүүд / сургуулийн сурагчидтай таарвал, дурсгал болгож зураг авахыг хүсэх нь энгийн үзэгдэл юм. Гагцхүү, энэ нь портретын эрхийг зөрчсөнд тооцогдох магадлалтай байдаг. Зарим хүмүүс зургаа авахуулахыг хүсдэггүй. Хэрвээ та хүүхдүүд / хүний зургийг авахыг хүсвэл, тэднээс урьдчилан зөвшөөрөл аваарай.

(5) Дэлгүүрүүд дотор бараа бүтээгдэхүүний зургийг авах

Их дэлгүүрүүд болон бусад дэлгүүрүүдэд бараа бүтээгдэхүүн гоёмсоор дэлгэж тавигдсан байдаг. Барааны үзүүлэнгийн арга техник болон загвар нь тэдний борлуулалтын үнэтэй нөү хау юм. Мөн, зураг авах нь, хулгай гэх мэт гэмт хэрэгт хэрэглэгдэх мэдээллийн эх үүсвэр болж болох учраас, тэд барааны үзүүлэнгийнх нь зургийг авахад хяналт тавьж, сэрэмжтэй байдаг. Эдгээр шалтгаануудын улмаас, дэлгүүрүүд дотор бараа бүтээгдэхүүний зургийг авахыг хориглодог.

(6) Тамхи татах

Япон улсын Эрүүл мэндийг дэмжих тухай хуулийн дагуу, Японы нийгэмд зөвхөн "Тамхи татах цэг"-т л тамхи татахыг зөвшөөрдөг. Иймээс олон нийтийн газарт тамхи та тахаас татгалзана уу. Арилжааны зочид буудлуудад, тамхи татахыг зөвшөөрдөг өрөөнд байрлаж байлаа ч гэсэн, тухайн өрөөний гаднах орчин нь тамхигүй орчин байдаг. Мөн, тамхи татахыг зөвшөөрдөг давхарт байсан ч, корридор болон лифт хүлээх талбайд тамхи татахыг хориглодог.



Кобэ, Осака гэх мэт том хотууд "Гудамжинд тамхи татахаас сэргийлэх" хорио журмыг баталж, гол гудмууд болон хүн хөдөлгөөн ихтэй бүсүүдийг "Гудамжинд тамхи татахыг хориглох бүс" болгон тогтоосон. Тус журмыг зөрчсөн хүмүүст торгууль (Кобэ, Осакад 1,000 иен) ноогдуулдаг. Иймээс, эдгээр бүсүүдэд асаалттай тамхи барьж явахаас татгалзана уу.

(7) Согтууруулах ундаа хэрэглэх

ЖАЙКА Кансай-д гуанз болон 4-р давхрын лаунж, мөн зочдын өрөөнөөс өөр бусад газарт согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно.



(8) Хог хаяхыг хориглоно

Кобэд хог хаяхыг захиргааны журмын дагуу хориглодог. Хэрвээ та хог хаявал, танд торгууль (20,000 иен хүртэлх хэмжээний) ноогдох болно. Бусад том хотууд мөн ижил төстэй захиргааны журамтай байдаг ба хогийг зориулалтын саванд нь хаях хэрэгтэй юм.

(9) Цахилгаан бараа худалдан авах - Нутагтаа хариад хэрэглэх боломжтой эсэхийг нь шалгаарай.

1) Тухайн бараагаа дэлгэрэнгүй мэдээллийнх нь талаар, ялангуяа нутагтаа харьсны дараа цахилгааны хүчдэл нь тохирох эсэхийг шалгаарай.

2) "Хэрэглэх заавар" нь Англи хэл дээр байгаа эсэхийг нягтлаарай.



2. Эрүүл мэндийн координатораас мэдээлэл хүргэж байна

(1) “БИЕ МАХБОДИЙН БИО ХЭМНЭЛ АЛДАГДСАН” байдлаас өөрийгөө сэргээх

Хүний биеийн био хэмнэлийг зохицуулахад үйлчилдэг өдрийн гэрэлд биеэ ил байлгахыг оролдохоос гадна, унтахынхаа өмнө хөнгөн хэлбэрийн дасгал хөдөлгөөн хийхийг хичээгээрэй.

(2) Гүний венийн тромбоз, эсвэл “Нислэгийн хямд зэрэглэлийн суудлын синдром”

Та нисэх онгоцоор зорчих явцдаа, удаан хугацаагаар, нэг ижил байрлалтайгаар суусан байж магадгүй юм. Хэрвээ танд хэвийн бус амьсгалын хүндрэл, цээжээр өвдөх, эсвэл хөл хөндүүртэй бөгөөд ихээр хавагнах шинж тэмдэг илэрвэл, Эрүүл мэндийн координатор, ЖАЙКА-гийн ажилтан, эсвэл Сургалтын координатор руу холбоо барина уу.

(3) Өдөр тутмын дадал хэвшил болгохыг санал болгож буй зөвлөмж

Эрүүл байхын тулд, гаднаас харьж ирэхдээ гараа сайтар угааж, давстай усаар амаа зайлахыг зөвлөж байна.

Зуны улиралд маш халуун, чийгшил өндөр байдаг болохоор, халуунд цохиулахаас зайлсхийхийн тулд, шингэнээ хангалттай нөхөөрэй.

(4) Өөртөө тариа хийх шаардлагатай оролцогчдоос хүсэх хүсэлт

Япон улсын Хог хаягдлыг хаях аргын тухай хуулиар, хэрэглэгдсэн зүү, тариур болон эмнэлгийн хэрэгслүүдийг олон нийтийн болон хувийн газарт хаяхыг бүх хүмүүст хориглодог. Хэрвээ та хэрэглэгдсэн эмнэлгийн хэрэгсэл хаях шаардлагатай бол, ЖАЙКА Кансай дахь Эрүүл мэндийн координатор, ЖАЙКА-гийн ажилтан, эсвэл Сургалтын координатор руу холбоо барина уу. Бид танд хэрэглэсэн эмнэлгийн хэрэгслүүдээ түр хадгалах жижиг сав өгөх ба таныг нутаг буцах үеэр таны хадгалсан зүйлсийг цуглуулж авна.

Японд цагаа сайхан өнгөрөөгөөрэй.

Эрүүл мэндийн координатор

Зохиогчийн эрхийн тухай баримтлах бодлого

МХББХ (Мэдлэг Хамтын Бүтээн байгуулалт Хөтөлбөр (Knowledge Co-Creation Program/ КССР))-ийн сургалтанд оролцогчид нь дараах "Зохиогчийн эрхийн тухай баримтлах бодлого"-ыг дагаж мөрдөх шаардлагатай;

1-р Зүйл Сургалтанд оролцогчид материал (төрөл бүрийн тайлан, үйл ажиллагааны төлөвлөгөө гэх мэт) болон презентаци (тайлан илтгэлийн уулзалт, лекц, яриа гэх мэт) боловсруулахад хамаарах комплаенстай холбоотой зүйлс

1. Аливаа материал болон презентацийн агуулгыг, зарчмын хувьд сургалтанд оролцогчид өөрсдөө боловсруулна.

2. Хэрвээ та, иш татах хязгаарт хэмжээнээс хэтэрсэн бөгөөд танай улсын хууль, дүрмээр, эсвэл зохиогчийн эрхэд хамаарах олон улсын гэрээ болон бусад ижил төстэй зүйлээр хамгаалагдсан гуравдагч этгээдийн ажил (хуулбар бүтээл, гэрэл зураг, зураг чимэглэл, газрын зураг, дүрс гэх мэт)-ыг ашиглах шаардлагатай бол, дараах зүйлсийг дагаж мөрдөнө. Үүнд:

- (1) Тухайн ажлыг ашиглах лицензийг өөрөө хариуцан авна. Энэ тохиолдолд, лицензийн хамрах хүрээ нь, 2 дугаар Зүйлийн заалтад нийцсэн байна.
- (2) Лицензийн зөвшөөрөл авсныг нотлох, лицензийн хүрээг тодорхой заасан нотолгоо баримтыг баталгаажуулна.
- (3) Лицензийн зөвшөөрлийг авах төлбөрийн хэмжээ, төлбөрийг хийх процедурын тухай тохиролцоход, өөрөө хариуцан гуравдагч этгээдтэй зөвшилцөж, төлбөрийг нь барагдуулна.

2-р Зүйл МХББХ-т ашигласан ажлуудын ашиглалтын тухай дэлгэрэнгүй

- (1) МХББХ-т зориулан сургалтанд оролцогчийн бэлдсэн ажлын зохиогчийн эрхийг тухайн оролцогч эзэмшинэ. Гуравдагч этгээдийн ажлыг ашигласан хэсгийн зохиогчийн эрхийг тухайн гуравдагч этгээд эзэмшинэ.
- (2) Сургалтанд оролцогчид нь, ЖАЙКА-гийн МХББХ-т зориулан тараагдсан сургалтын материал болон нэмэлт материалуудыг ашиглахдаа, тухайн материал тус бүрийн зохиогчийн эрхийг эзэмшигчийн зөвшөөрсөн тухайн материалыг ашиглах зорилго, ашиглах хүрээний дагуу ашиглана.

(Тус бодлогыг "ЖАЙКА-гийн "Мэдлэг Хамтын Бүтээн байгуулалт Хөтөлбөр"-т оролцох өргөдөл бичих зааварчилгаа"-наас иш татав.)

ЖАЙКА-гийн Байгаль орчны бодлого

1. Үндсэн концепци

Хүн төрөлхтөний хамгийн чухал үүрэг хариуцлага бол, ирээдүй хойч үедээ баялаг бөгөөд олон янзын төрх бүхий байгаль орчныг үлдээх явдал билээ.

Хэмжээ, цар хүрээ нь нэмэгдсээр байгаа хүний үйл ажиллагаанаас улбаалан, хэд хэдэн ноцтой байгаль орчны асуудлууд бий болсон. Тухайлбал, дэлхийн дулаарал, озоны давхаргын цоорол, агаарын бохирдол, хог хаягдлаас улбаалсан байгалийн бохирдол, хөрсний бохирдол, ойгүйдэл, цөлжилт. Эдгээр нь бүгд хүн төрөлхтөний ирээдүйг эрсдэлд оруулах асуудлууд юм.

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (цаашид "ЖАЙКА" гэнэ.) нь, хүн төрөлхтөний оршин тогтнол болон дэлхий дээрх хэвийн амьдралд маш чухал нөлөө үзүүлэх эх дэлхийнхээ байгаль орчныг тууштай хамгаална. Үүний зэрэгцээ ЖАЙКА нь, байгаль орчны хамгаалал, нийгмийн элбэг хангалуун байдал, тогтвортой хөгжил хоорондын тэнцвэрийг нь тааруулахыг хичээж байна.

2. Үндсэн бодлогын удирдамж

"Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Ерөнхий дүрмийн хууль"-д заасны дагуу, ЖАЙКА-гийн эрхэм үүрэг нь, "Хөгжиж буй гадаадын орнууд, бүс нутгуудын эдийн засаг болон нийгмийн хөгжил, эсвэл шинэчлэн байгуулалт, эсвэл эдийн засгийн тогтвортой байдалд нь хувь нэмэр оруулах замаар, олон улсын хамтын ажиллагаа болон Япон ба олон улсын нийгэм, эдийн засгийн эрүүл хөгжилд хувь нэмэр оруулах" бөгөөд ялангуяа, байгаль орчны хууль, дүрмийн комплаенсын тухайд, дэлхийн байгаль орчныг хамгаалахад хувь нэмрээ оруулах явдал юм. Цаашилбал, ЖАЙКА-гийн үйл ажиллагаанаас шалтгаалан, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө үүсэхээс сэргийлж, үүсэх сөрөг нөлөөг бууруулахын тулд, ЖАЙКА нь байгаль орчны менежментийн системийг ашиглах бөгөөд уг системээ сайжруулахад тасралтгүй хичээн ажиллана. Энэхүү систем нь дараах бодлогод тулгуурлана.

(1) Олон улсын хамтын ажиллагааны үйл ажиллагаагаараа дамжуулан, байгаль орчны арга хэмжээг дэмжих

Япон улсын засгийн газрын Хөгжлийн албан ёсны тусламж (ODA)-ийн бодлогод тулгуурлан, ЖАЙКА нь байгаль орчныг хамгаалах, сайжруулахад чиглэсэн хамтын ажиллагааны үйл ажиллагааг дэмжиж ажиллана. ЖАЙКА нь дараах ажлуудыг цаашид үргэлжлүүлэн хийнэ. Үүнд:

- Хөгжиж буй орнуудын байгаль орчныг хамгаалахад хувь нэмэр оруулах олон улсын хамтын ажиллагаа болон төслүүдийг дэмжих; мөн түүнчлэн,
- Байгаль орчин, нийгэмд ээлтэй байдлыг хангах удирдамжийн дагуу, хөгжлийн хөтөлбөр, төслүүдийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах.

(2) Байгаль орчны талаарх ерөнхий ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих

Олон нийтийн ухамсрыг нэмэгдүүлэх зорилгоор, ЖАЙКА нь байгаль орчны асуудлын тухай мэдээлэл цуглуулна. ЖАЙКА нь дараах ажлуудыг цаашид үргэлжлүүлэн хийнэ. Үүнд:

- ЖАЙКА-гийн байгаль орчны асуудалтай холбогдох хөтөлбөрүүдийг танилцуулах замаар сургалтын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Байгаль орчны асуудлын талаарх судалгааг хийж, холбогдох саналыг боловсруулах; мөн түүнчлэн,
- ЖАЙКА-гийн ажиллагсад болон ЖАЙКА-гийн үйл ажиллагаанд гар бие оролцож буй бусад боловсон хүчнүүдэд зориулсан семинар, зааварчилгаа өгөх сургалт зохион байгуулах замаар холбогдох хүмүүсийг тасралтгүй сургах.

(3) ЖАЙКА-гийн офисууд болон ЖАЙКА-гийн бусад байгууламжууд дээрх байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих

ЖАЙКА нь, өөрийн офисууд болон бусад байгууламжууд дахь үйл ажиллагаанаас үүсэх аливаа сөрөг нөлөөг бууруулах байгаль орчны хөтөлбөрийг дэмжинэ. ЖАЙКА нь дараах ажлуудыг цаашид үргэлжлүүлэн хийнэ. Үүнд:

- Хог хаягдлыг бууруулах, нөөц болон эрчим хүчийг хэмнэх, дахин боловсруулахыг дэмжих; мөн түүнчлэн,
- "Ногоон худалдан авалтын хууль" болон бусад холбогдох хууль, дүрмийг үндэслэн, байгаль орчинд ээлтэй бараа бүтээгдэхүүнийг авах.

(4) Байгаль орчны хууль, дүрмийн комплаенс

ЖАЙКА нь холбогдох байгаль орчны хууль, дүрмийг тууштай дагаж мөрдөнө. Энэхүү "Байгаль орчны бодлого"-ыг ЖАЙКА-гийн бүх ажиллагсад болон ЖАЙКА-гийн нэрийн өмнөөс ажиллаж буй бүх боловсон хүчинд мэдээлэхээс гадна уг бодлогын талаар олон нийтэд мэдэгдэнэ.

2015 оны 10 дугаар сарын 1-ний өдөр
Шин-ичи Кита-ока
Ерөнхийлөгч
Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага

Ач тустай зарим цахим хуудас, аппликейшн

- Японы хөтөч

<http://www.japan-guide.com/>



Японы аялал жуулчлалын талаар мэдээлэл хайж байна уу? Энд дарна уу!

- Японы үндэсний аялал жуулчлалын байгууллага

<http://www.jnto.go.jp/eng/>

Та Японд жуулчдын сонирхлыг татах төрөл бүрийн газруудыг олох болно!



- CLAIR

<http://www.clair.or.jp/tagengo/>

(Орон нутгийн захиргааны байгууллагуудын олон улсын харилцааны консул)



Японы талаарх үндсэн мэдээллийг төрөл бүрийн хэл дээр авах боломжтой!

- Гайхамшигтай Япон, NHK

<https://www4.nhk.or.jp/cooljapan/>

Японы хамгийн сүүлийн үеийн хандлагуудыг олж мэдээрэй! Гайхамшигтай биш гэж үү?



- Олон хэлний ярианы орчуулгын аппликейшн

Хэрвээ танд Япон хүнтэй харилцахад хүндрэлтэй санагдаж байгаа бол, "VoiceTra (Дуу хоолой таньж орчуулагч)" гэдэг олон хэлний ярианы орчуулгын аппликейшныг татаж аван, ашиглаж үзэх талаар бодож үзээрэй. Энэхүү үнэ төлбөргүй аппликейшныг Дотоод хэрэг, харилцааны яамны тусламжтайгаар, Мэдээлэл, харилцааны технологийн үндэсний институтээс санаачилсан консорциумаас нээж гаргасан ба уг аппликейшн нь таны яриаг таны хүссэн нийт 31 хэл рүү (2018 оны 4-р сарын байдлаар) орчуулна. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудаснаас харна уу.

<http://voicetra.nict.go.jp/en/index.html>

